

ГАРЧИ

Г

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	7
2.1 Судалгааны талбайн байршил.....	7
2.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл.....	7
2.3 Геологийн тогтоц ба геоморфологи.....	8
2.4 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар.....	9
2.5 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол.....	10
2.6 Ургамлан бүрхэвч.....	10
2.7 Амьтны аймаг.....	11
2.8 Тусгай хамгаалалттай газар.....	14
2.9 Нийгэм-эдийн засгийн нөхцөл.....	14
3 ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	16
4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	24
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	26
4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	27
4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	28
4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	30
5 ДҮГНЭЛТ.....	32

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн хашаан дахь барилга байгууламжууд.....	5
Зураг 2. Цахилгаан хангамжийн эх үүсвэр.....	5
Зураг 3. Ус цэвэршүүлэх төхөөрөмж болон унд ахуйн усан хангамжийн худаг..	6
Зураг 4. Төслийн талбайн байршлын тойм зураг.....	7
Зураг 5. Судалгааны талбайн өндөржилтийн зураг.....	9
Зураг 6. Гадаргын налуужилт.....	9
Зураг 7. Судалгааны талбай болон тусгай хамгаалалттай газар нутгийн байршил.....	14
Зураг 8. Ажилчдын хотхон орчмын шороон замын сүлжээг харуулсан хиймэл дагуулын зураг.....	16

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Жил, сарын агаарын дундаж температур, °С.....	7
Хүснэгт 2. Жил, сарын нийлбэр хур тунадас, мм.....	8
Хүснэгт 3. Гүний худгийн усны найрлага.....	10
Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	19
Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл...	22
Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал.	31

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус “Ажилчдын хотхон” төсөл нь нэг удаад 435 хүн хүлээн авах хүчин чадалтай юм. 2018-2019 оны байдлаар тус хотхонд 30-40 хүн байрлаж байна.

Тус төслийн үндсэн зорилго нь Тавантолгой болон тухайн бүсэд хэрэгжиж байгаа уурхайн хүнд машин, механизмын засвар үйлчилээний төвийн ажилчдын амьдрах нөхцлийг хангах зорилготой юм.

“Ажилчдын хотхон” нь нийт 5 барилгаас бүрдэнэ. Үүнд:

1. Ажилчдын дотуур байр нь 4261.98 м² талбайтай бөгөөд унтлагын өрөө, угаалгын өрөө, амралт-тоглоомын өрөө зэргээс бүрдсэн бөгөөд угсралтын полистрол хавтангаар барьсан 2 давхар барилга болно.
2. Спорт танхим болон бялдаржуулах танхим нь 945 м² талбайтай.
3. Ажилчдын цайны газар нь 783 м² талбайтай бөгөөд хоол бэлтгэл, угаалга, мах бэлтгэл, хөргүүрийн өрөө, хооллох танхим зэргээс бүрдэнэ.
4. Үйлчилгээний барилга нь эмнэлэг, мини маркет, интернэт танхимаас бүрдэх бөгөөд 287.75 м² талбайтай юм.

Техник үйлчилгээний барилга нь 684.0 м² талбайтай бөгөөд ус цэвэршүүлэх байгууламж, бохир ус цэвэршүүлэх байгууламж, генератор болон цахилгаан удирдлагын өрөөнөөс бүрдэнэ.







Зураг 1. Төслийн хашаан дахь барилга байгууламжууд

Эрчим хүч

MCS ХХК-ийн цахилгаан станц болон 2 дизел генератороос цахилгаан эрчим хүчийг хангаж байна.



Зураг 2. Цахилгаан хангамжийн эх үүсвэр

Усны хэрэглээ

Тус ажилчдын хотхон нийт 435 хүн хүлээн авах хүчин чадалтай. Ажилчдын хотхон нь дотороо усанд орох душтэй. Иймд унд ахуйн усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалын 12-р хавралтын дагуу 1 хүн 1 хоногт 150 л ус хэрэглэнэ гэж үзэв. Иймд унд ахуйн ус хэрэглээнд 1 хоногт $435 \text{ хүн} \cdot 150 \text{ л/хүн} = 65.25 \text{ м}^3$ буюу 0.75 л/с байна.

Тус төсөл нь усны хэрэгцээгээ өөрсдийн эзэмшил талбайн хашаанд гаргасан гүний худгаас хангадаг. Тус худгийн гүн 100 м, ундарга 3.2 л/с байна. Худгаас

ирэх усыг шууд унд ахуйд ашиглахгүй бөгөөд ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр дамжуулан ашиглана.



Зураг 3. Ус цэвэршүүлэх төхөөрөмж болон унд ахуйн усан хангамжийн худаг

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2.1 Судалгааны талбайн байршил

“Вагнер Ази Спин” компанийн эзэмшлийн “0004758” тоот газар ашиглах гэрчилгээтэй талбай нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутагт харьяалагдах бөгөөд сумын төвийн зүүн урд хэсэгт оршино.



Зураг 4. Төслийн талбайн байршлын тойм зураг

2.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл

Судалгааны талбай орчмын уур амьсгалын нөхцөл нь эх газрын эрс тэс, нэн хуурай, дулаан хээр-говийн мужид багтана. Уур амьсгалын эрс тэс шинж нь хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижил зун нь халуун, өвөл нь харьцангуй дулаавтар, хавар салхи шуурга их, хуурайшил ихтэй байдгаар илэрнэ.

Судалгааны талбай орчмын уур амьсгал эх газрын эрс тэс шинжтэй. Агаарын сарын дундаж температурын агууриг 36.1°C байна.

Хүснэгт 1. Жил, сарын агаарын дундаж температур, °C

Станц	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
Даланзадгад	-14.7	-10.7	-2.8	6.4	14.3	19.5	21.4	19.6	13.5	5.0	-5.0	-12.2	4.5
Цогтцэций	-15.1	-10.3	-3.7	5.6	13.4	19.4	21.7	19.1	13.1	4.8	-4.4	-11.3	4.4

Тус нутгаар жилдээ дунджаар 107.5 - 130.1 мм хур тунадас ордог байна. Жилийн дулааны улиралд хур тунадасны 91.1 - 92.9% /98.0- 120.9мм/ нь, харин

хүйтний улиралд маш бага хэсэг 9.5-9.6 мм ордог нь Монгол орны хур тунадасны горимын нэг онцлог юм.

Хүснэгт 2. Жил, сарын нийлбэр хур тунадас, мм

Станц	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
Даланз адгад	1.2	1.6	3.1	4.9	11.0	22.0	33.5	33.5	11.3	4.3	2.3	1.4	130.1
Цогтцэций	1.6	2.8	2.1	3.5	9.0	18.5	35.9	34.0	13.8	4.3	1.7	1.3	107.5

2.3 Геологийн тогтоц ба геоморфологи

Судалгааны талбайд доод Карбон (C₁)-ын настай цайвар ногооноос хөх саарал өнгийн элсэн чулуу тархана. Талбайн баруун хойд хэсгээр хадан гарш гадаргууд ил гарсан байх ба хадан хөрсийг 0.2-0.3 м зузаан салхины гаралтай элсэн хөрс хучиж тогтоно.


Судалгааны талбайн дээд хэсгээр 0.1 м зузаантай өнгөн хөрс болон 0.2-0.3 м-ийн зузаантай салхины гаралтай элсэн хөрсүүд тархаж, эдгээр хөрсний доороос ногоон саарлаас хөх саарал өнгийн доод карбоны C₁ настай элсэн чулуу илэрнэ. Элсэн чулуулаг нь гадаргуугаас 1.1-1.5 м хүртэл өгөршсөн байдалтай түүнээс доош сулавтар өгөршсөн байдалтай илэрч байна.

Хадан хөрсийг хучиж тогтсон бага зузаантай бор шаргал өнгийн, салхины гаралтай тоосорхог элсэн хөрс нь чийг багатай, сул нягттай илэрсэн болно. Талбайд тархсан өгөршсөн элсэн чулуу нь ан цав ихтэй нягт байдалтай бөгөөд өгөршсөн элсэн чулуунд байгалийн нягт $\rho=2.55 \text{ гр/см}^3$, өгөршлийн илгэлцүүр $K_{wg}=0.87$, нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх бат бөхийн хязгаар:

- Байгалийн чийгтэй үед $R_c=5-15 \text{ МПа}$
- Усаар ханасан нөхцөлд $R_c=7-10 \text{ МПа}$
- Сулавтар өгөршсөн хадан хөрсөнд байгалийн нягт 2.71 гр/см^3 , өгөршлийн илгэлцүүр $K_{wg} = 0.90$, нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх бат бөхийн хязгаар:
- Байгалийн чийгтэй үед $R_c=20-30 \text{ МПа}$
- Усаар ханасан нөхцөлд $R_c>15 \text{ МПа}$

Төслийн талбай нь геоморфологийн нэг төрлийн элементэд оршино. Гадаргуугийн байдал ерөнхийдөө тэгшивтэр бөгөөд урдаасаа хойшоо ялимгүй хэвгий тогтоцтой. Талбайн баруун хойд хэсгээр хадан гарш илэрч гарсан бөгөөд гуу жалга зэрэг физик геологийн үзэгдэл үйл явц хөгжөөгүй, ан цавын усгүй зэргээс үзэхэд инженер геологийн энгийн нөхцөлтэй. Судалгааны талбай нь

1480-1490 м өндөрт орших бөгөөд гадаргын хувьд тэгш тал буюу 0-3⁰ налууутай байна.



Зураг 5. Судалгааны талбайн өндөржилтийн зураг



Зураг 6. Гадаргын налуужилт

2.4 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар

Төслийн талбайн гидрогеологийн нөхцөлийг бичихдээ “Вагнер Ази Спин” ХХК-ийн Ажилчдын хотхон төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангийн гидрогеологийн хэсгээс ашиглав. Тус тайлангийн гидрогеологийн бүлгийг бичихдээ Өмнөговь аймгийн гидрогеологийн тулгуур бүтээлүүд болон Өмнөговь аймгийн Усны аж ахуйн байгууллага, судлаачдын 1974-2007 оны хооронд нийт 33 жилийн хугацаанд хийсэн гидрогеологи-геофизикийн тайланг ашигласан гэж өгүүлжээ.

Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 1974-2007 оны хооронд гаргасан 20 гаруй цооногуудын гидрогеологийн үзүүлэлтүүдэд анализ хийж үзэхэд цооногийн дундаж гүн 97.2 м, уст үеийн дундаж интервал 68.1-83.0 м, уст үеийн дундаж зузаан 14.9 м, статистик дундаж түвшин 29.4 м, динамик дундаж түвшин 44.4 м, дундаж ундарга 2.0 л/с байна.

Судалгааны талбай орчимд байнгын урсгал болон тогтмол устай гол горхи байхгүй. Колдышева. Р.Я. нарын зохиосон гидрогеологийн 1:500000 зурагт Улаан нуур хэмээх тойрмыг “шорвог устай нуур” гэж тэмдэглэсэн байдаг. Гэвч уг тойромд сүүлийн олон жилийн туршид ус хуримтлагдаагүй байна. Энэ Улаан нуур гэдэг нь тухайн нутгийн иргэдийн нэрлэж байгаа тэрхэн хэсгийн жижиг тойрмыг нэрлэж байгаа бөгөөд говийн Улаан нуур /Мандал-Овоо сумын нутагт байдаг/ биш юм.

Тавантолгойн нүүрсний орд газрын нутаг дэвсгэр нь хэдийгээр Монгол орны ус зүйн мужлалаар “түр урсгал бүхий, горхитой муж”-д хамаарагдах боловч энэ Ажилчдын хотхон орчимд гадаргын ус үндсэндээ байхгүй гэж үзэж болно. Учир нь энэ талбайн эргэн тойрны 15-25 км-д цөөн тооны гар худаг, бороо ихтэй үед

ус тогтдог жижиг тойром, 1.2 л/с-ээс ихгүй ундаргатай ганц нэг шанд байх бөгөөд тэдгээр нь байнгын биш устай байдаг.

Тус төсөл нь усны хэрэгцээгээ өөрсдийн эзэмшил талбайн хашаанд гаргасан гүний худгаас хангадаг. Худгийн координат: N 43° 43' 02.0" E 105° 35' 21.7" h=1489 м. Тус худгийн гүн 100 м, ундарга 3.2 л/с, усны тогтсон статик түвшин 16.2 м, 1-р уст үеийн байрлал 18.6-21.9 м, хоёрдугаар уст үеийн байрлал 53.4-60.1 м байна.

Хүснэгт 3. Гүний худгийн усны найрлага

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	323.1	9.1	56.1	Na ⁺ +K ⁺	170.9	7.43	45.8
SO ₄ ⁻	225.0	4.69	28.9	Ca ²⁺⁺	126.3	6.30	38.8
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ²⁺⁺	30.4	2.50	15.4
NO ₃ ⁻	0.6	0.10	0.6	NH ₄ ⁺	0.1	0.01	0.0
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	143.4	2.35	14.5	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	697.4	16.23	100.0	Дүн	327.6	16.23	100.0

Тус худгийн усны ерөнхий хатуулаг 8.8 мг-экв/дм³, исэлдэх чанар 4.64 мг/дм³, рН 7.68 байна. Химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натри-кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд давсархаг, хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, натри, кальц, магнийн ионын агууламж нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-д заасан хэмжээнээс их байгуу тул хүний унданд тохиромжгүй, цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаадлагатай.

2.5 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол

4758 тоот газар ашиглах гэрчилгээтэй талбайд Монгол орны хөрсний ангилалаар хээржүү цөлийн хөрсний бүлэгт багтах сайргархаг Бор төрлийн хөрс зонхиолон тархсан байна. Эдэлбэр газрын 55.4% буюу 1.66 га талбай шууд нөлөөлөлд өртсөн байна. Энэ хөрс нь эвдрэл талхагдалд дунд зэрэг өртсөн, хөрсний шимт үе давхаргын зузаан дунджаар 15 см, ялзмагийн агууламж маш бага, хөдөлгөөнт калийн хангамж сайн, хөдөлгөөнт фосфорын хангамж маш бага байна. Хөрсний урвалын орчин хүчтэй шүлтлэг, карбонатын болон хялбар уусах давсны агууламж бага. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр 6 төрлийн элементээр “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу одоогоор хөрсний бохирдол үүсээгүй байна.

2.6 Ургамлан бүрхэвч

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалтаар хувьд Евразийн хээрийн их муж, Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Цогтцэцийн районд хамрагддаг.

Судалгааны талбайд хялгана–алаг өвст бүлгэмдэл тархах бөгөөд бүлгэмдэлийн зонхилогч зүйл нь *Stipa gobica*-говийн Хялгана, *Ajania achileoides*-төлөгчдүү Боролзой. *Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс, *Caragana leucophloea*, *Caragana stenophylla* ургамлууд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ *Artemisia pectinata*-өмхий Шарилж, *Eragrostis minor*-бага Хургалж, *Chloris virgata*-саваан Булган сүүл, *Setaria viridis*-ногоон Хоног будаа, *Carex duriuscula*-ширэг Улалж зэрэг ургамлууд зонхилон ургасан. Энэхүү бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал дунд зэрэг доройтолд орсны улмаас уг бүлгэмдэл флорын баялагаараа ядмаг болсон байна. Тухайн бэлчээрт доройтлыг илэрхийлэгч ургамлууд зонхилсон байна. Бэлчээрийн төрлийн дундаж өндөр 30см, ерөнхий тусгаг бүрхэц 43 хувь, зонхилогч болон дэд зонхилогч зүйл ургамлууд сор1 арвийн үнэлгээтэй. Судалгааны талбайн 3 га талбайг бүрдүүлж байна. Бэлчээрийн ургац 200-300кг/га байх ба түүний 50%-ийг үетэн, 25-30%-ийг төлөгчдүү Боролзой эзлэнэ.

2.7 Амьтны аймаг

Өмнөговь аймаг Төв Азийн их говь цөлийн бүсэнд оршино. Төслийн талбай орчмын газар нутаг нь амьтны газарзүйн мужлалын хувьд Хойд говийн тойрогт хамаарна (А.Г.Банников 1954).

Судалгааны талбайгаас зүүн өмнө алсад Цогтцэций уул түүний салбар толгод, хойд хэсэгтээ Цанх, Цогтцэцийн намхан бор толгод үргэлжилнэ. Цэций уулын арын сайр садаргаар ихээхэн хэрчигдсэн харгана, буйлст, хайрга чулуурхаг зарим хэсэгт хужир мараа бүхий дэрс, түнгэт хотгортой хур тунадас элбэг үед ус ундрагатай байдаг онцлогтой.

Хээрийн судалгаа болон урд өмнө хийсэн судалгаа, ном бүтээлээс магадлахад судалгааны талбай, Цэций уул орчимд 7 багийн 29 зүйлийн хөхтөн амьтад байршин нутагладаг болохыг тогтоолоо.

Амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын I хавсралтад (хулан адуу), II хавсралтад орсон (аргаль хонь, шилүүс мий, мануул мий, саарал чоно) 5 зүйл байгаа нь төслийн үйл ажиллагааны үед хууль бус агнууртай тэмцэх, сурталчилгаа хийхэд анхаарах шаардлагатай болно. Энд дурьдсан хулан адуу нь энэ нутагт 10-аад жилийн өмнө хэвийн байршин нутаглаж байсан боловч уул уурхайн нөлөөгөөр Монгол орны тархац нутаг нь энэ хэсгээр тасархайтан маш ховордсон. Гэхдээ онцгой нөхцөлд нүүдэл шилжилт хийх үедээ энэ нутгаар дайран өнгөрөх, түр байрших боломжтой тул тухайн үед хамгаалах арга хэмжээ авах төлөвлөлт хийх шаардлагатай. Мөн Цэций уулан дахь аргаль хонь, янгир ямаа дайжин тоо толгой цөөрч байгааг онцгой анхаарч хамгааллын биотехникийн арга хэмжээ төлөвлөх шаардлагатай байна. Бусад зүйлүүд нь идэш тэжээл бологч мэрэгчтэн ховордсон нөхцөлд дайжин өөр нутагт шилжих боловч мөн нүүдэл шилжилт хийх үедээ тохиолдох магадлалтай.

Агнуурын ач холбогдолтой 9 зүйл байна. Үүнээс 5 зүйл нь ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр агнадаг. Үлдсэн 5 зүйл амьтныг амьтны тухай хуулинд заасан хугацаанд агнах боломжтой байдаг. Гэхдээ эдгээр зүйл нь мөн л уурхайн нөлөөгөөр дайжин алга болно.

Төслийн талбай дахь хөхтөн амьтдаас олон улсын үнэлгээгээр устаж болзошгүй 1 зүйл, ховордож болзошгүй 5 зүйл, эмзэг зэрэглэлд 5 зүйл, анхааралд өртөхөөргүй 18 зүйл байна.

Бүс нутгийн үнэлгээ буюу Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд үнэлэгдсэн байдлыг авч үзвэл устаж болзошгүй 2 зүйл, ховордож болзошгүй 6 зүйл, эмзэг 2 зүйл, анхааралд өртөхөөргүй 13 зүйл, мэдээлэл дутмаг 12 зүйл байна. Гэхдээ энэ мэдээлэл дутмаг гэдэг үнэлгээ нь говийн алагдаага, козловын атигдаахай, өөхөн-сүүлт атигдаахай зэрэг ховор амьтдын үнэлгээг тодорхойгүй болгосон. Иймээс Ажилчдын хотхоны талбай орчимд эдгээр амьтдыг ховор амьтдын адил үзэж хамгааллын арга хэмжээ авах шаардлагатай.

Туруутан (*Artiodactyla*)

*Хар сүүлтуй (*Gazella subgutturosa*):* Энэ зүйлийг олон улсын үнэлгээгээр эмзэг (ЭМ), A2ad, бүс нутгийн үнэлгээ эмзэг (ЭМ), A3cde гэсэн зэрэглэлд оруулсан. Нэлээд уудам тархацтай боловч хэсэг хэсэг нутагт тасархайтан хумигдаж тоо толгой, нягтшил нь багассаар байгаа.

Засгийн газрын 7-р тогтоолоор (2012) ховор амьтны жагсаалтад оруулсан. Монгол улсын улаан номын гурван удаагийн хэвлэлд бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; Шийрэвдамба нар, 2013). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон ч гадаадын анчдад агнах тусгай зөвшөөрөл олгодог. Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн II хавсралтад бүртгэсэн. Аргаль хонины тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар орсон.

Тархац нутаг нь сүүлийн хэдэн арван жил нэлээд тасархайтсан байна. Монгол Алтай, Говийн Алтай нурууны аргаль хонины тархац нутаг малын тоо толгой өссөнтэй холбоотой бэлчээрээр шахагдах ялангуяа төллөдөг гол газруудад айл мал нутагласнаас тасархайтан хумигдсаар байна.

Энэ төслийн талбайд нэлээд аргаль хонь байрших бөгөөд ялангуяа Цэций ууланд байнга тогтвортой байршдаг. Мөн зэргэлдээх уулсаар улирлаас шалтгаалан өргөн хоолой хөндийг гатлан нүүдэл шилжилт хийдэг. Хавар ногоо хөөн нам тал бэлд бууж бэлчээрлэнэ.

Туурайтан (*Perissodactyla*)

Хулан адуу (Equus hemionus): Энэ зүйлийн олон улсын үнэлгээ нь эмзэг (ЭМ) зэрэглэлтэй бөгөөд бүс нутгийн үнэлгээ нь устаж болзошгүй (УБ) гэсэн статустай. Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн I хавсралтад бүртгэсэн. Засгийн газрын тогтоолоор (2012 оны №7) ховор амьтны жагсаалтад оруулсан. Монгол улсын улаан номын гурван удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр орсон байна.

Махчман (Carnivora)

Говийн шилүүс мий (Lynx lynx isabellina): Монгол оронд 2 салбар зүйл байдаг. Энэ зүйлийн олон улсын болон бүс нутгийн нь үнэлгээгээр ховордож болзошгүй (ХБ) гэсэн статустай байна. Монгол оронд өргөн тархсан боловч тархалт нь жигд бус. Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн II хавсралтад бүртгэсэн.

Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн II хавсралтад бүртгэсэн.

Мануул мийн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

Олон улсын хэмжээнд арьсыг нь худалдаалдаг тул хараа хяналтгүй агнаснаар энэ зүйлийн тоо толгой буурсан гэж үздэг. Гэрийн нохой болон махчин шувуудын дайралтанд өртдөг, говийн бүсийн жижиг мэрэгчдийн тоо толгойн хэлбэлзлэлээс тархац нутаг тоо толгой хамааралтай.

Мэрэгчтэн (Rodentia)

Бордуу шишүүхэй (Cricetulus migratorius): Энэ зүйлийн олон улсын үнэлгээ нь ховордож болзошгүй (ХБ), манай орны үнэлгээ нь мэдээлэл дутмаг (МД) гэсэн үнэлгээтэй байна. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань, Дорнод говийн хэд хэдэн газарт тохиолджээ. Тархац нутгийн 33 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газар бөгөөд булаг, шандны ширгэлт, татралт, ган гачиг зэрэг ховордох шалтгаан болно.

Шувууд

Төслийн талбай орчимд тархсан шувуудыг амьдралын хэлбэр нь голчлон хээржсэн цөлд амьдрах бөгөөд гандуу нутгийн жижиг уул, толгодод амьдардаг шувуудын бүрдэл юм. Энэ нутагт жилийн турш байнга амьдардаг ойр зуур бага зэрэг нүүдэл хийх боловч суурин амьдардаг 15 зүйл шувуу байдаг. Эдгээрээс 2 зүйл монгол улсын улаан номонд данстай, 6 зүйл шувуу CITES-ийн конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн.

Манай оронд хавар 3-р сарын дунд үеэс ирээд, өндөглөн зусаад, намар 10 сарын сүүлч болоход буцдаг (нүүдлийн, өндөглөдөг) 23 зүйл шувуу


тэмдэглэгдсэн байна. Дээрх шувуудаас 3 зүйл монгол улсын улаан номонд данстай, 8 зүйл шувуу CITES-ийн конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн. Жороо тоодгой (*Chlamydotis undulate*) гэх нэг зүйл шувуу Азийн болон Монгол улсын улаан номонд данслагдсан.

Судалгааны талбай орчимд тархсан мөлхөгчид

Судалгааны талбай орчмын нутагт 12 зүйл мөлхөгчид байрших бөгөөд зүйл тус бүр өөр өөрийн амьдрах бичил орчинд тохиолдох онцлогтой. Эдгээрээс 1 зүйл (тэмээн сүүл могой) CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн, 4 зүйл нь ховордож болзошгүй, 2 зүйл улаан номонд орсон амьтад бөгөөд бусад зүйлүүд өргөн тархацтай анхааралд өртөхөөргүй зүйлүүд юм.

2.8 Тусгай хамгаалалттай газар

Судалгааны талбай нь тусгай хамгаалалттай газар нутгаас хол зайтай оршдог. Хамгийн ойр орших тусгай хамгаалалттай газар нутаг нь талбайгаас баруун тийш 88 км-т “Говь гурван сайхан” байгалийн нөөц газар, зүүн хойш 135 км-т “Загийн-Ус” байгалийн нөөц газар юм.



Зураг 7. Судалгааны талбай болон тусгай хамгаалалттай газар нутгийн байршил

2.9 Нийгэм-эдийн засгийн нөхцөл

Өмнөговь аймгийн Цогтцэций сум анх 1924 онд байгуулагдсан. Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, өөрийн аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшинээс 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна.

Булаг, шанд, уул, толгод, говь хөндий, хоолой хослосон байгалийн эрдэнэс баялагаар баян, Монгол Улсын баатар эмэгтэй Т.Борын өлгий нутаг, Гэсэр гэлэнгийн домогт хурдан хул мориор домголсон Говь шанхын хурдан удмын адуу, арвин баялаг нөөцтэй “Тавантолгой” нүүрсний орд зэргээр алдартай нутаг юм.

Тус сум нь чулуун нүүрс, гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, алт, зэс, хужир зэрэг эрдэс баялгаа хөрсөн дороо агуулсанаас гадна эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж түүнийг даган сум орон нутагт дэд бүтэц хөгжиж, хөгжил цэцэглэлтийн шинэ эрин үетэй зэрэгцэн хөгжих боломж бүрдсэн нутаг юм.

“Таван толгой” ХК, “Энержи ресурс”, “Эрдэнэс таван толгой” зэрэг уул уурхайн томоохон компаниуд олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг.

Засаг захиргааны анхан шатны нэгж болсон Сийрст, Өгөөмөр, Сийрст, Билгэх гэсэн 4 багтай, сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус сумын нийт хүн ам 7030, хөдөлгөөнт хүн ам 16100, өрхийн тоо 2315-д хүрсэн байна. 2014 онд байдлаар 75156 толгой мал тоолуулсан. Мал таван төрөл дээрээ 9415 толгойгоор өссөн.

Тус онд 12.5 га талбайд ногоо тарьсанаас 156.7 тн ургац хурааж авлаа. Сумын хэмжээнд 288 аж ахуй нэгж, жижиг бизнес эрхлэгч 1290 иргэн үйл ажиллагаагаа явуулж байна. Худалдаа үйлчилгээний газрууд жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал: Эмийн сан-5, Хүнсний үйлдвэрлэлийн тоо-10, Зочид буудал-29, Хүнсний дэлгүүр-36, Супермаркет-10, Хүнсний бөөний төв-5, Нийтийн хоолны газар-37 болж нэмэгдсэн байна.

3 ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал:

Байгаль орчны физик шинж чанарын өөрчлөлт: Тус төслийн үндсэн үйл ажиллагаа нь ажилчдын амрах, амьдрах нөхцлийг хангах учир байгалийн эрдэс баялаг, ургамал, амьтаны нөөц ашиглахгүй болно. Тус төслийн цаг хугацааны хамрах хүрээ нь жилийн турш үргэлжлэх бөгөөд 4-р сараас 10-р сар хүртэл хамгийн өндөр ачаалалтай ажиллана. Оронзайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөлөлд өртсөн газар 1.66 га буюу эдэлбэр газрын 55.4% байна. Сумын төв, Таван толгой, түүнийг тойрсон уул уурхайн компаниуд, үйлдвэрүүдийн ажилчид энэхүү ажилчдын хотхонд ирж байрладаг. Иймээс энд тэндээс ирэх хүмүүсийн хөдөлгөөнөөр ажилчдын хотхоныг тойрсон шороон зам их хэмжээгээр үүссэн байгааг хиймэл дагуулын зургаас харж болно.



Зураг 8. Ажилчдын хотхон орчмын шороон замын сүлжээг харуулсан хиймэл дагуулын зураг

Шороон зам нь салхины хурд ихтэй үед тоосжилтын эх үүсвэр болно. Мөн хөрсний элэгдэл, эвдрэлийн шугаман эх үүсвэр болох бөгөөд цаашид энэ хэвээр үлдээвэл шинж чанарын хувьд нэн эмзэг, маш нимгэн ялзмагт давхаргатай, үл нөхөн сэргэх нөөц болох говийн хөрс устгах эрсдэл өндөр байна.

Тус төсөлд унд-ахуйн усны хэрэглээг газрын доорх уснаас буюу худагас хангадаг. Говийн бүсийн газрын доорх усны нэг онцлог бол эрдэсжилт ихтэй (1120 мг/дм^3), дундаж хатуулаг 5.4 мг-экв/дм^3 байдаг учраас хүний унданд хэрэглэх зохимжтой хэмжээнээс их байдаг. Ийм учраас төсөл хэрэгжүүлэгч ус цэвэршүүлэх төхөөрөмж суурьлуулан газрын доорх усыг цэвэршүүлэн унд-ахуйд хэрэглэж байна. Ус цэвэршүүлэх үед 1 сард 1 удаа фильтрүүдийг цэвэрлэдэг. Цэвэрлэгээнээс үүсэх шингэн хаягдал нь аюултай шинжтэй байдаг.

Одоогоор төсөл хэрэгжүүлэгч шууд хөрсөнд зайлуулж байгаа нь хөрсний чанарт сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Унд ахуйгаас гарах бохир усыг цэвэрлэх байгууламжид цэвэрлэн MCS компанийн ухаа худгийн бохир ус цэвэрлэх байгууламжид нийлүүлж байна. Хаягдал бохир усыг цэвэрлэх төхөөрөмжийн механик цэвэрлэгээний үе шатанд хатуу хаягдал үүсдэг. Энэ хаягдал нь аюултай шинжтэй хаягдал болох бөгөөд энгийн хог хаягдалтай цуг хадгалах нөхцөлд хөрсний чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Мөн нян, бактер үржих нөхцөл бүрдэнэ. Унд ахуйн хэрэглээтэй холбоотойгоор 1 сард 3.9 тн буюу ихээхэн хэмжээний хаягдал үүснэ. Унд ахуйн хаягдлыг зориулалтын орчинд ангилан ялгаж хадгалахгүй нөхцөл нян, бактер үржих нөхцөл бүрдэхээс гадна үнэрийн бохирдол үүсгэнэ. Ялангуяа хоол бэлтгэх хэсэг, зоогын газраас гарах хоол, хүнсний хаягдлыг зориулалтын саванд, шаардлага хангасан нөхцөлд хадгалахгүй нөхцөлд үнэрийн бохирдол үүсэх, нян, бактераар хөрс бохирдсоноор ажилчдын хотхонд ирэх зочин, гийчний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Цахилгаан хангамжид дизель генератор ашиглах бөгөөд дизелийг 2 зориулалтын саванд хадгаладаг. Энэ саванд дизель хийх үед болон дамжуулах хоолойгоор дизель дамжих үед хөрсөнд алдагдах эрсдэлтэй боловч төсөл хэрэгжүүлэгч ачих буулгах талбайг хатуу хучилттай болгосон. Мөн агуулах сав нь зориулалтын учраас хээрийн судалгааны үед шатах тослох материал асгарсан ул мөр илрээгүй болно.

Биологийн буюу экологийн нөөц: Төсөл хэрэгжих талбайн орчим ой мод, чийг намгархаг газар байхгүй. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй түүх, соёлын үнэт зүйлс байхгүй.

Судалгааны талбайд жижиг дэгнүүлт үетэн – жижиг алаг өвст бүлгэмдэл тархах бөгөөд бүлгэмдэлийн зонхилогч зүйл нь *Stipa gobica*-говийн Хялгана, *Ajania achileoides*-төлөгчдүү Боролзой, *Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс, *Caragana leucophloea*, *Caragana stenophylla* ургамлууд бүрдүүлж байна. Олон салаа шороон замын шууд болон шууд бус нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтож, устаж байна.

Хүний хэрэглээний үнэ цэнэ: Төсөл хэрэгжих талбайд өмнө нь мал бэлчээрлэдэг байсан бөгөөд бэлчээрийн талбай 3.0 га-аар багасна. Тус ажилчдын хотхоныг сүлжилдсэн олон салаа шороон зам нь шугаман элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлнэ. Геологийн судалгааны үр дүнгээс үзэхэд тус талбайд ашигт малтмалын нөөц байхгүй.

Амьдралын чанар: Тус төсөл хэрэгжсэнээр эдэлбэр газрын хүрээнд дунжаар 435 хүн байрлах бөгөөд хүн амын нягтшил 145 хүн/га болно. Ингэснээр байгалийн аливаа аюул осолд өртөгдөх байдал нэмэгдэнэ. Орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний татвар төлнө. Орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг, дасан зохицсон амьдралд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Төсөл

хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчимд эмнэлэг, сургууль, шашны мөргөлийн газар, орон нутгийн нийтийн үйлчилгээний барилга байгууламж зэрэг нүүлгэн шилжүүлэхэд хүндрэл учруулахуйц, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутаг байхгүй.

Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцалттай	Буцалтгүй
1. Байгаль орчны физик шинж чанарын өөрчлөлт								
Хөрсөн бүрхэвчид өөрчлөлт орох эсэх	Y	N	N	N	N	Y	Y	N
Геоморфологийн нөхцөлд өөрчлөлт орох эсэх	Y	N	N	N	N	Y	N	Y
Газрын доорх усны нөөцыг хомсдуулах эсэх	N	Y	N	Y	N	N	Y	N
Байгалийн эрдэс баялгийн нөөц ашиглах эсэх	N	N	N	N	N	N	N	N
Химийн бодисын ашиглалттай холбоотой орчны чанарт өөрчлөлт оруулах эсэх	N	N	N	N	N	N	N	N
Барилга, байгууламж барьж байгуулахтай холбоотой хатуу хог хаягдал гарах эсэх	Y	N	N	N	N	Y	Y	N
Шингэн хаягдлаас усны чанарт нөлөөлөл үзүүлэх эсэх	Y	N	N	N	Y	N	Y	N
Агаарт хийн хаягдал ялгаруулах эсэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Агаарт физик бохирдол үүсгэх эсэх	Y	N	N	Y	N	N	Y	N
2. Биологийн буюу экологийн нөөц								
Ургамлын нөөц баялаг	Y	N	N	N	N	Y	N	Y
Ойд модны нөөцөд нөлөөлөх эсэх	N	N	N	N	N	N	N	N
Чийг намгархаг газарт нөлөөлөх эсэх	N	N	N	N	N	N	N	N
Түүх, соёлын үнэт зүйлс	N	N	N	N	N	N	N	N
Биологийн төрөл зүйлд нөлөөлөх эсэх	Y	N	N	N	N	Y	N	Y
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт								
Ундны усны чанар	Y	N	N	Y	N	N	Y	N
Урсгал усны хэрэглээ	N	N	N	N	N	N	N	N
Тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүр дэхь шаталтаас үүсэх хорт хийн агаар орчин үзүүлэх нөлөөлөл	Y	N	N	Y	N	N	Y	N
Шатах тослох материалын хэрэглээтэй холбоотойгоор хөрсний чанарт гарч болзошгүй өөрчлөлт	Y	N	N	Y	N	N	Y	N
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх	Y	N	N	Y	N	N	Y	N

4. Хүний хэрэглээний үнэ цэнэ								
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	Y	N	N	N	N	Y	N	Y
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	Y	N	N	N	N	Y	N	Y
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	N	N	N	N	N	N	N	N
5. Амьдралын чанар								
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	Y	N	N	Y	N	N	Y	N
Орон нутгийн орлого нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	Y	N	N	Y	N	N	Y	N
Ажлын байр нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	Y	N	N	Y	N	N	Y	N
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	N	Y	N	Y	N	N	Y	N
	19	2	0	13	1	7	16	5

Y - Тийм

N - Үгүй

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Ажилчдын хотхон байгуулах төслийн үйл ажиллагааны үед уг төслийн байршил, техник-технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “+” гэж бөглөв (хүснэгт 21).

Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл: Тус төсөл нь толгод хоорондын хөндий хотос газраар сайргархаг бор хөрстэй, жижиг дэгнүүлт үетэн – жижиг алаг өвст бүлгэмдэл бүхий хүний үйл ажиллагаанд нэн эмзэг ландшафтад байрлах тул төслийн орчмын эмх замбараагүй үүссэн олон салаа шороон зам, түүнээс дэгдэх тоос, тоосонцор зэргээс хүчтэй нөлөөлөлд орох магадлал өндөр юм. Тус төслийн эдэлбэр газрын орчимд үерийн урсац бүрэлдэхээр гуу, жалга, хуурай сайр, гол, горхи байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал: Ажилчдын хотхон нь зочин гийчин хүлээн авах үндсэн барилга, зоогийн газар, цахилгаан эрчим хүчний дэд станц, дизель генератор, дизель түлш хадгалах сав, ус цэвэршүүлэх төхөөрөмж, хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж, бохирын цооног, авто зогсоол зэргээс бүрдэнэ. Бусад ажигчдын хотхонтой харьцуулахад нэг онлцог шийдэл нь ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, ус цэвэрлэх байгууламж зэрэг юм. Эдгээр нь хэдийгээр усны чанарыг сайжруулж, хаягдал бохир усыг цэвэршүүлж байгаа боловч технологийн явцад аюултай хог хаягдал үүсгэх сул талтай байна. Иймээс энэхүү аюултай хог хаягдлыг түр хадгалахдаа холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллах хэрэгтэй.

Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал: Хог хаягдлыг ангилан ялгахгүй, зориулалтын бүс саванд, шаардлага хангахгүй нөхцөлд хадгалаж байгаас хөрс бохирдох, үнэрийн бохирдол үүсэх зэргээр эрүүл ахуйн нөхцөлд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Тус төсөл нь үйлдвэрлэлийн бус төсөл боловч цахилгааны эх үүсвэртэй бууруу харицах, гал алдах, байгалийн хүчин зүйлээс хамаарсан осол аваар гарах магадлалтай юм.

Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд: Төсөл хэрэгжих эдэлбэр газрын хэмжээ 3 га бөгөөд энэ хэмжээгээр уламжлалт аргаар мал маллах талбайн хэмжээ багасч байна.

Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
			бага	дунд	их
1. Төслийн байршилтэй холбоотой байгаль орчны асуудал					
1.1	Голын гольдролыг эвдэж өөрчлөх	+			
1.2	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал			+	
1.3	Ой модыг огтлох, гэмтээх	+			
1.4	Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдвор газрыг эвдэхэд хүрэх		+		
1.5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх		+		
1.6	Булаг, шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	+			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал					
2.1.	Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, технологи, орчны хяналтанд сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой.				+
2.2.	Осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн				+
2.3.	Газрын доорх ус бохирдуулагчаас хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой				+
2.4.	Саарал усыг дахин ашиглах талаар тусгагдсан эсэх		+		
2.5.	Тоосжилт дарахад ашиглах технологийн шийдэл	+			
2.6.	Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт бодис, тоосонцор гардаг эсэх	+			
2.7.	Дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх	+			
3. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд					
4.1.	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг алдах		+		
4.2.	Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх			+	

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон үр дүнгээс үзэхэд нийт нөлөөллийн 63 % нь шууд, 6.6 % нь шууд бус нөлөөлөл бөгөөд гол нөлөөлөл нь унд-ахуйн хатуу хог хаягдал, ус цэвэршүүлэх төхөөрөмж, цэвэрлэх байгууламжийн хаягдал, эдэлбэр газрыг тойрсон олон салаа шороон зам зэрэг юм.

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчин-эдийн засаг

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, засаг захиргааны нэгжийн хөгжлийн хөтөлбөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Улс орны эдийн засагт дараах хэлбэрээр хувь нэмэр оруулна.

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- Нийгмийн л шимтгэл
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Байгалийн нөөц баялаг ашиглахгай холбогдох татвар, төлбөрүүд

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба ОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжинэ.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч “Барловорлд Монголиа” ХХК-ийн нь байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллана. Ингэснээр байгаль орчны календарьчилсан төлөвлөгөө гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

“Барловорлд Монголиа” ХХК нь экологи-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байгаль орчны бодлогоо дараах хэлбэрээр тодорхойлсон.

- Компанийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах асуудал нь чухал ач холбогдолтой байна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд учруулах нөлөөллүүдийг хүрч болох хамгийн бага түвшинд байлгахаар хянана.
- Компаний байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах хууль, журам, стандарт
Дээврийн усыг хуримтлуулж ногоон байгууламжид ашиглах	Усны нөөцийг хэмнэх	м	15	15	225	Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
Цогтцэций сумын төвөөс ажилчдын хотхон хүртэлх шороон замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	Хөрсний элэгдэл, эвдрэл, агаарын чанар	ш	6	30	180	MNS 4597:2014
Нийт зардал					405.0	

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		500ш мод тарих		ш	500	1.5	1250.0	5, 10 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн - Эзэмшил талбайн 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж бий болгох	Тарьсан мод, сөөгийг арчилж ургуулах, зүлэгжүүлэх	Өөрийн эзэмшил талбайд	ш	500	1.0	300.0	5-10 сар	
3	Нийт, мян.төг						1550.0		

4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
2	Ердийн	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан хадгалж, цуглуулж байх. - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Хуванцар хаягдал - Тостой хаягдал - Ерөнхий хаягдал - Хоол хүнсний хаягдал - Шатах тослох материалын хаягдал	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
3		Энгийн хог хаягдлыг ТҮК-тай гэрээгээ сунган гэрээний дагуу зайлуулж байх	Хог хаягдлын хуримтлал	Удаа	55000	12	Гэрээний дагуу	Сар бүр	- Хог хаягдлын тухай хууль - MNS 5344:2011
4		Ахуйн бохир усыг “Ухаа худаг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байх	Шингэн хог хаягдал	Удаа	-	4	Гэрээний дагуу	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
5		Хоол хүнсний хаягдлыг бокаши бордоо болгох	Хольцын нөлөө бууруулах	Иж бүрэн	95.0	2	190.0	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
Нийт							190.0		

4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: PM2.5, PM10 SOx NOx COx Дуу шуугиан	- Ажилчдын хотхоны хашаа - Ажилчдын амрах байр - Цайны газар	Жилд 1 удаа	-	Өөрийн багажаар	MNS 4585:2016 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Хөрсөн бүрхэвч	- Агрохими - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Нефтийн бүтээгдэхүүн - Бактереологи	- Хашаан дотор - Хог хаягдал түр хадгалах талбай	Жилд 1 удаа	55.0	110.0	MNS 5850:2008
Ус	- Хүнд металл - Анион, катион - Бактереологи	- Худгийн ус - Ундны ус цэвэрлэх төхөөрөмж	Жилд 1 удаа	48	96	MNS 900:2018 Усны тухай хууль
Нийт зардал					206.0	

4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь, сар												Хариуцсан албан тушаалтан	Тайлбар	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	Тухайн жилийн БОМТ-г БОАЖЯ-р батлуулах	-														БО-ы мэргэжилтэн	БОНБУ-ий тухай хууль
3	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг Өмнөговь аймгийн БОГ-т хүргүүлж, дүгнүүлэх	-														БО-ы мэргэжилтэн	БОНБУТ хууль, БОАЖ-ын сайд А/618
4	Ус ашиглуулах дүгнэлтийг Өмнөговь аймгийн байгаль орчны газраар гаргуулах	50														БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
5	Сумын ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах, эрхийн бичиг авах	-														Захирал	Усны тухай хууль
6	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг бууруулах, хөдөлмөр хамгаалал, галын аюул, осол эрсдлийг бууруулах сургалтыг зохион байгуулах	50.0														БО-ы мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
7	Нийт зардал, мян.төг	100.0															

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн

байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тухай	10 сард	50.0	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Цогтцэций сум, Сийрст баг
2	БОМТ-ий биелэлтийн тайланг аймгийн БО-ы газраар дүгнүүлэх	3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Өмнөговь аймгийн БОАЖГ
3	Нийт зардал, мян.төг				50.0		

Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	405.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1550.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	390.0
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	100.0
5	Орчны хяналт шинжилгээ	206.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	50.0
	Нийт зардал, мян.төг	2701.0

5 ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Ажилчдын хотхон” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2018 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэв. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 2701.0 мян.төг (хоёр сая долоон зуун нэг мянган төгрөг) болно.